



АРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/37

Эрдэнэбулган сум

Эмийн сангуудыг уртасгасан цагаар
ажиллуулах тухай

“Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоол, “Удирдамж батлах тухай” Улсын Онцгой комиссын даргын 2020 оны 04 дүгээр тушаал, “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/93 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (COVID-19)-ын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, иргэдэд эмийн сангийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор 2 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн өндөржүүлсэн бэлэн байдлыг цуцлах хүртэл хүртэлх хугацаанд аймгийн нийт эмийн сангуудыг уртасгасан цагаар ажиллуулсугай.

2. Эмийн сангуудын ажиллах цагийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Эрдэнэбулган сумын эмийн сангуудын ажиллах цагт хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Б.Уран-Учралд, сумдын эмийн сангуудын ажиллах цагт хяналт тавьж ажиллахыг сумын эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гамшгаас хамгаалах Эрүүл мэндийн албаны штабын дарга /Д.Өлзийсайхан/-д даалгасугай.

ДАРГА  Р.ГАНДИЙМАА

6512000117

ЭМГ-ын даргын 2020 оны 02 сарын 23-дрийн
А/37 тоот тушаалын 1-р хавсралт

Эмийн сангуудын ажиллах цагийн хуваарь

№	Нэр	Байршил	Ажиллах өдөр	Ажиллах цаг
1	Хөдөөгийн бүх сумдын эмийн сан	Бүх сумын төвд	Өдөр бүр	08.00-24.00
2	Аз таван булаг	Хасу худалдааны төв дотор	Даваа-Бямба	10.00-18.00
3	Богд хайрхан	Тэрх худалдааны төв дотор	Даваа-Бямба	10.00-19.00
4	Гурван эрдэнэ	2-р 36 байранд	Өдөр бүр	09.00-22.00
5	Дэлгэрмөрөн	Кактус худалдааны төв дотор	Даваа-Бямба	09.00-20.00
6	Замбал	Гост супермаркет дотор	Өдөр бүр	09.00-22.00
7	Монгол эм импекс - 1	Цагдаагийн газрын урд талд	Өдөр бүр	09.00-24.00
8	Монгол эм импекс - 2	1-р 36 байранд	Өдөр бүр	09.00-22.00
9	Мөнгөт Оюу	Хасу худалдааны төвийн хойд талд	Өдөр бүр	09.00-24.00
10	Сүмбэр	2-р 48 байранд	Өдөр бүр	09.00-23.00
11	Хаш	4-р 36 байранд	Өдөр бүр	09.00-23.00
12	Элбэг	47-р байранд	Өдөр бүр	24 цагаар
13	Өвгөнхад	Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн 3-р давхарт	Даваа-Баасан	09.00-18.00
14	Өгөөмөр Жинст	2-р 36 байранд	Өдөр бүр	08.00-24.00
15	Өнө Энх	28-р байранд	Өдөр бүр	09.00-24.00
16	Монос Ач	1-р 36 байранд	Өдөр бүр	09.00-24.00